

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
ТАВАНТОЛГОЙН ОРДЫН ЦАНХИЙН ЗҮҮН ХЭСГИЙГ АШИГЛАХ “ТЕХНИК, ЭДИЙН  
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ” БОЛОН ЦАНХИЙН БАРУУН ХЭСГИЙГ АШИГЛАХ “ТЕХНИК  
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ”-ИЙН ТОДОТГОЛ, ШИНЭЧЛЭЛ ХИЙЛГЭХ АЖЛЫН  
ДААЛГАВАР**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
ТАВАНТОЛГОЙН ОРДЫН ЦАНХИЙН ЗҮҮН ХЭСГИЙГ АШИГЛАХ “ТЕХНИК, ЭДИЙН  
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ” БОЛОН ЦАНХИЙН БАРУУН ХЭСГИЙГ АШИГЛАХ “ТЕХНИК  
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ”-ИЙН ТОДОТГОЛ, ШИНЭЧЛЭЛ ХИЙЛГЭХ АЖЛЫН  
ДААЛГАВАР**

**1. ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

- 1.1. Захиалагч: “Эрдэнэс-Таван толгой” ХК
- 1.2. Ерөнхий зөвлөх: Ерөнхий зөвлөхийг тендерээр сонгон шалгаруулна.
- Зөвлөх нь чадавхаа нэмэгдүүлэх үүднээс хамтарсан байдлаар оролцож болно.
- 1.3. Удирдагч: ТЭЗҮ, төсөлд зөвлөгөө өгөх Монгол улсын зөвлөх инженер байна.
- 1.4. Төслийн хүчин чадал:
  - Цанхийн зүүн уурхай 20.0 сая тн/жил нүүрс олборлох,
  - Цанхийн баруун уурхай 20.0 сая тн/жил нүүрс олборлох
- 1.5. Төслийн үе шат: Техник-эдийн засгийн үндэслэлээр тодруулна.
- 1.6. Төслийн хүчин чадлаа эзэмших хугацаа: Техник-эдийн засгийн үндэслэлээр тодруулна.
- 1.7. Гүйцэтгэх хугацаа:
  - Эхлэх 2019 оны ... -р сарын ...
  - Дуусах 2019 оны ... -р сарын ...
- 1.8. Төсөл боловсруулах үндэслэл: 2011 оны 4 дүгээр сарын 8-ны болон 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “ЭБМЗ”-ийн санал, дүгнэлтэнд нийцүүлэх, 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 074 тоот Эрдэс баялаг эрчим хүчний сайдын тушаалаар батлагдсан журам, 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 73-р тогтоол.
- 1.9. Ажлын зорилго:
  1. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн ордын Цанхийн зүүн уурхайн “Техник эдийн засгийн үндэслэл” болон Цанхийн баруун уурхайн “Техник эдийн засгийн үндэслэл” /цаашид “ТЭЗҮ” гэх/-д тодотгол, шинэчлэлт хийж “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл” /цаашид “ЭБМЗ” гэх/-ийн хурлаар хэлэлцүүлэх, шинжээчдийн өгсөн санал шүүмжийн дагуу өөрчлөлт оруулах, батлуулах.
- 1.10. Ашиглах материал:
  - Геологи хайгуулын ажлын тайлан
  - Байрзүйн зураглал, Гидрогеологийн зэрэг хавсралт тайлангууд
  - “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн уурхайд хийгдсэн хажуугийн тогтворжилт, гадаргуугийн ерөнхий төлөвлөлт гэх мэт судалгааны ажлын тайлангууд

- 2011, 2012 оны ТЭЗҮ, 2019 оны Техникийн хараат бус тайлан.
- Жил бүрийн уурхайн Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Уурхайн үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн байгууллагын хяналтын дүгнэлт гэх мэт

1.11. Программ хангамж:

Геологи, уул уурхайн зориулалттай өөрийн эзэмшлийн холбогдох программ хангамж ашиглан гүйцэтгэх. Тухайн программ хангамж ашиглан гаргасан үр дүн, файлын өргөтгөлийг MICROMINE болон MINEX программ дээр ашиглагдахаар байх.

1.12. Гүйцэтгэх ажлын хэмжээ:

- Техникийн даалгаварын дэлгэрэнгүй тайлбарыг тендерт шалгарсаны дараа хүлээлцэх
- Гүйцэтгэгч техникийн даалгавар болон түүний дэлгэрэнгүй тайлбарт үндэслэн ТЭЗҮ-ийн бүтцийг боловсруулж захиалагчид танилцуулж, баталгаажуулна.

1.13. Нэмэлт ажил

- “Эрдэнэс – Тавантолгой” ХК хөрөнгийн зах зээлд хувьцааг арилжаалахтай холбоотойгоор Олон улсын зөвлөхийн боловсруулсан тайлангийн техникийн баримт бичигтэй шаардлагатай хэсгүүдийг уялдуулах, тайлан болон хавсралтуудыг Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлнэ.

## 2. ТӨСӨЛД ШААРДЛАГАТАЙ ҮНДСЭН ӨГӨГДЛҮҮД БА ОНЦЛОГ НӨХЦӨЛ

- 2.1. Хэрэглэх материалууд: Орд дээр хийгдсэн өмнөх судалгаа, тайлан, мэдээлэл, холбогдох материалаар Захиалагч хангана. Холбогдох материал, ажлын дэлгэрэнгүй тайлбар, жагсаалтыг тендерт шалгарсаны дараа хүлээлцэх
- 2.2. Онцлог нөхцөл, тухайлсан судалгаа:
- Шинэчлэгдсэн нөөцийн тооцоог үндэслэн төлөвлөлтийг оновчилж, уурхайн урт хугацааны уулын ажлын ахилтын хүрээг жил бүрээр тогтоох ба уурхайн загварчлалыг шинэчлэн боловсруулна. Уурхайн гадаад, дотоод хөрсний овоолго, шимт хөрс, шимэрхэг хөрсний овоолго, бусад төрлийн овоолгуудын байршил, хэмжээг жил бүрийн тээврийн зайтай календарчилсан байдлаар /1-5 дахь жилд улиралаар, цаашдын жилүүдэд жил бүрээр / тодорхой харуулах.
  - Зах зээлийн эрсдэл, нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл цаг хугаандаа ашиглалтад орохгүй байх үед ашиглах эхний 5 жилийн уурхайн олборлолтын төлөвлөлтийг хувилбараар, улиралаар боловсруулах.
  - Уурхайн үйл ажиллагааны одоогийн нөхцөл байдлыг дүгнэж, уурхайг ашиглах явцад тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа, тооцоо, дүгнэлт боловсруулна.
  - Цанхийн Зүүн, Баруун уурхай, хөрсний овоолгын хажуугийн тогтворжилтын судалгааг хийж, дүгнэлт гарган уурхай, хөрсний овоолгын загварчлалын үзүүлэлтийг нарийвчлан гаргана. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д Геотехникийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани болон зөвлөхтэй хамтрана. Уурхайн чулуулгийн төрөл, шинж чанарын үзүүлэлтэд уялдаж, тогтворжилтыг хангасан загварчлал, ашиглалтын параметрийг оновчлох.
  - Цанхийн Баруун уурхайн хөрс хуулалтанд автоконвейерийн хосолсон тээвэртэй мөчлөг-урсгал технологийн иж бүрдэл нэвтрүүлэх боломжийн талаар ТЭЗҮ-д тусгах.
  - Цанхийн баруун уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо, чулуулгийн бутлагдлын хэмжээг конвейерийн туузны өргөнөөр хязгаарлагдах нөхцлөөр цооногийн диаметр, цооног болон эгнээ хоорондын зай зэргийг хэд хэдэн хувилбараар харьцуулалт хийж оновчтой хувилбарыг гаргах.
  - Цанхийн зүүн, баруун уурхайн ухаж ачих тоног төхөөрөмж, техникүүдийн ашиглалттай холбоотой орол, ажлын талбайн өргөн, доголын өндөр, налуу зэрэг мөргөцөгийн элементүүдийг оновчлох. Ашиглагдах тоног төхөөрөмжийн сонголт, ашиглалтын системийн параметрийг бодит байдалд нийцүүлэх.
  - Цанхийн баруун уурхайн хөрсний 2-р овоолгын байршлын сонголт, дүгнэлт хийх. Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх, шийлжүүлэхгүй байх үеийн харьцуулалт хийх.
  - Цанхийн зүүн баруун уурхайн гадаргын усыг зайлуулах арга, үерийн усны хамгаалалт хийх. Улаан нуурын хөндий орчим гадаргын усан сан үүсгэх, хиймэл нуур үүсгэх судалгааг хийх. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д

Гидрогеологийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани болон зөвлөхтэй хамтрана. Уурхайн шүүрлийн усны тооцооллыг нарийвчилан гаргаж, ус татах, шилжүүлэх үйл ажиллагааг тодорхой харуулах.

- Ус хангамжийн асуудал, хэтийн төлөвийн талаар санал, дүгнэлт гаргах.
- Борлуулалтын байдал, дүгнэлт, Зах зээлийн судалгаа, үнийн хэтийн төлөв хандлага тодорхойлж, ТЭЗҮийн үзүүлэлтийг тооцох
- Нүүрсний нарийн үеүд дээр олборлолт хийх техникийн шийдэл гаргах, тусгах (2м-с бага үе)
- Агуулахаас хэрэглэгчийн автомашинд нүүрс ачих шийдлийг оновчлох, мөн төмөр зам ашиглалтанд орох үеийн вагонд ачилт хийх шийдлийг тооцох.
- Эрчим хүчний нүүрсний чиглэлийг тодорхойлох судалгаа хийж санал, дүгнэлт гаргах.
- САЖА маркийн нүүрсийг ашиглан бордооны үйлдвэр барих санал, дүгнэлт гаргах.
- Уурхайн усалгаанд орчин үеийн дэвшилтэт арга технологи ашиглах шийдэл гаргах, эдийн засгийн харьцуулсан тооцоолол гаргах.
- Уурхайн агааржуулалтын тооцоо хийж ТЭЗҮ-д тусгана.
- “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Цанхийн Зүүн Баруун уурхайн хөрс хуулалтын хөрөнгө, түүний элэгдлийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлалыг судлан дүгнэлт гаргах.
- Цанхийн Зүүн, Баруун уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөлтийг хооронд нь уялдуулах, оновчтой шийдэл гаргаж гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн гаргана.

### **3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН:**

Ашигт малтмалын тухай хууль, газрын хэвлийн тухай хууль, байгаль орчны тухай хууль, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан “Уул уурхайн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”, “Уул уурхайн график зураг, бичиг баримтын стандартууд” болон холбогдох бусад журам, стандарт, аргачлал, Монгол Улсад мөрдөгдөж буй хуульд нийцүүлэн гүйцэтгэнэ. Бусад шаардлагатай хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтүүдийг тодотголд тусгана.

Мөн 2011 оны 4 дүгээр сарын 8-ны болон 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “ЭБМЗ”-ийн санал, дүгнэлтэнд нийцүүлнэ.

### **4. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- 4.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн зураг төсөл боловсруулах Хөнгөн ба хүнд үйлдвэр, уул уурхайн зураг төслийн 1.5.1 тоот тусгай зөвшөөрөлтэй байна.
- 4.2. Гүйцэтгэгч нь чадавхаа нэмэгдүүлэх үүднээс хамтарсан байдлаар оролцож болно.
- 4.3. Монгол улсад тухайн чиглэлээр 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллага байна.
- 4.4. Геологи, уул уурхайн холбогдох программ хангамж ашигладаг байна.
- 4.5. Өмнө нь уурхайн 10-аас доошгүй ордын жилд 20-с дээш сая м<sup>3</sup> уулын цулын ажил гүйцэтгэх хүчин чадал бүхий ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна. Үүнээс нүүрсний уурхайн 5-аас доошгүй ордын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна.
- 4.6. Зөвлөх инженер болон мэргэшсэн инженерийн багтай байх бөгөөд багийн голлох мэргэжилтэн нь 15 аас доошгүй, бусад мэргэжилтнүүд нь 5 аас доошгүй жилийн ажлын туршлагатай байна.
- 4.7. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт /2018 оны ... сарын ...-ны өдрөөс хойш/
- 4.8. Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт /2018 оны ... сарын ...-ны өдрөөс хойш/

### **5. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА:**

- 5.1. Нүүрсний ордын геологийн иж бүрэн загварчлал, нөөцийн тайланг боловсруулж байсан туршлагатай байна. (өөрийн эзэмшлийн программ хангамж ашигладаг байна.)
- 5.2. Ил уурхайн стратеги төлөвлөлт үе шатны хүрээ хийх иж бүрэн сонголтуудтай нүүрсний үнийн өөрчлөлт, ашгийн өөрчлөлт, зардлын өөрчлөлтөөр хүрээ үүсгэх) загварчлал хийх. (өөрийн эзэмшлийн программ хангамж ашигладаг байна.)
- 5.3. Өрөмдлөг, тэсэлгээний параметрийн оновчлолын загварчлал боловсруулах, чулуулгийн бутлагдалд анализ хийх. (өөрийн эзэмшлийн программ хангамж ашигладаг байна.)
- 5.4. Чулуулгийн тогтворжилт хананы гулсалт шилжилт хөдөлгөөн, хагарлын олон янзын байдлын загварчлал хийх (өөрийн эзэмшлийн программ хангамж ашигладаг байна.)
- 5.5. Уулын ажлын төлөвлөлт, оновчлол, өрөмдлөг, тэсэлгээ, геотехникийн программууд дээр хийгдсэн боловсруулалтын талаар албан ёсны программууд дээр сургалт хийх

- 5.6. Сүүлийн 3 жил (2016, 2017, 2018) аль нэг жилд 100 саяаас доошгүй орлогын дүнтэй байх.
- 5.7. Татварын байгууллагын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойш/

#### **6. ЭЦСИЙН ТАЙЛАН:**


ТЭЗҮ-ийн тодотгол, шинэчлэлийг зохих дүрэм, журмын дагуу боловсруулж, шинжээчдийн өгсөн санал шүүмжийн дагуу өөрчлөлт оруулан батлагдсан тайлан, хавсралт материалуудыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр захиалагч байгууллагад 4 хувь ирүүлнэ. /Эцсийн тайлан болон хураангуйг Монгол хэлээр бэлтгэж ирүүлнэ/.

#### **7. ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:**

Тус ажлыг гэрээ байгуулснаас хойш 3 сард багтаан гүйцэтгэж, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө.

##### **Баталсан:**


Үйлдвэрлэл, уул уурхайн газар  
хариуцсан дэд захирал



Г.Дэлгэрбаяр

##### **Хянасан:**

Уул уурхайн хэлтсийн дарга  
Геологи, хайгуулын хэлтсийн дарга




Ц.Анхбаяр

Г.Сумъяагарав

##### **Бэлтгэсэн:**

Ерөнхий инженер  
Уул уурхайн хэлтсийн ахлах инженер



Ч.Батбаатар

Г.Бат-Эрдэнэ

2019 оны 04-р сарын 16.